



“СҮЛД-АУДИТ” ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“НОМИН ЮНИТИ ББСБ” ХХК

*2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар
болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Улаанбаатар хот

2024 он



Г “НОМИН ЮНИТИ ББСБ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД Т

СҮЛД-АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Бага тойруу 8 дугаар хороо, 11-р
хороолол GB-центр #502 тоот
Утас:(976) 93098181, 99114056
E-mail: info@suld-audit.mn

2024.03.26 № 24/11
танай _____ -ны № _____

Г ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН Т

Санхүүгийн тайлангийн талаарх аудитын тайлан

Өөрчлөлтгүй дүгнэлт

Бид “Номин юнити ББСБ” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь “Номин юнити ББСБ” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох заавар, журмын дагуу бүх материаллаг зүйлсийг хамруулан үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлага энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Монгол Улсын аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай, зохистой үндэслэл болно гэж үзэж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг.

Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Санхүүгийн тайлангуудтай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв шударгаар толилуулах болон залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, компанийн чадамжийг үнэлж, тодруулах шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Хүндэтгэсэн,
Сүлд-Аудит ХХК
Гүйцэтгэх Захирал




Ч.ГҮНДБАЯР

**“НОМИН ЮНИТИ ББСБ” ХХК-ИЙН
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх**

	(төгрөгөөр)	
Үзүүлэлтүүд	2022/12/31	2023/12/31
1. Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	448,887,047.67	529,380,687.86
Богино хугацаат хөрөнгө оруулалт	33,861,920.00	33,861,920.00
Зээл цэврээр	11,774,872,159.41	21,158,299,406.57
Бусад авлага	176,779,689.27	259,332,909.12
Бусад хөрөнгө	1,763,092.24	7,407,829.87
Эргэлтийн хөрөнгийн дүн	12,436,163,908.60	21,988,282,753.42
2. Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	30,089,385.1	34,777,119.43
Тавилга, эд хогшил	20,681,187.87	23,488,041.64
Тавилга, эд хогшлын хуримтлагдсан элэгдэл	(1,947,777.18)	(3,766,305.70)
Техник хэрэгсэл	23,142,420.24	34,705,657.24
Техник хэрэгслийн хуримтлагдсан элэгдэл	(11,786,445.81)	(19,650,273.75)
Биет бус хөрөнгө	0.00	0.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	30,089,385.12	34,777,119.43
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,466,253,293.72	22,023,059,872.85
3. Богино хугацаат өр төлбөр		
Бусад өглөг	5,508,946,875.24	2,795,619,330.10
Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,508,946,875.24	2,795,619,330.10
4. Урт хугацаат өр төлбөр		
Банк, санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,508,946,875.24	2,795,619,330.10
Нийт өр төлбөрийн дүн	5,508,946,875.24	2,795,619,330.10
5. Эздийн өмч		
Энгийн хувьцаа	2,500,000,000.00	12,500,000,000.00
Хувьцаат капиталын дүн	2,500,000,000.00	12,500,000,000.00
Хуримтлагдсан ашиг/алдагдал	4,457,306,418.48	6,727,440,542.75
Эздийн өмчийн дүн	6,957,306,418.48	19,227,440,542.75
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,466,253,293.72	22,023,059,872.85

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**“НОМИН ЮНИТИ ББСБ” ХХК-ИЙН
АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ТАЙЛАН
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх**

Үзүүлэлтүүд	(төгрөгөөр)	
	2022/12/31	2023/12/31
Хүүгийн орлого	1,877,748,514.04	4,180,044,771.38
Хүүгийн зардал	48,488,931.53	
Цэвэр хүүгийн орлого	1,829,259,582.51	4,180,044,771.38
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн орлого	489,631,755.11	1,153,463,075.65
Бусад үйл ажиллагааны орлого	17,072,683.40	42,429,660.56
Хүүгийн бус орлогын нийт дүн	506,704,438.51	1,195,892,736.21
Үндсэн үйл ажиллагааны нийт орлогын дүн	2,335,964,021.02	5,375,937,507.59
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал	183,486,862.78	943,209,103.06
Боловсон хүчний зардал	309,424,238.72	549,280,634.00
Бусад зардал	255,029,287.84	480,025,042.19
Хүүгийн бус зардлын дүн	747,940,389.33	1,972,514,779.25
Зээлийн эрсдэлийн зардал	118,259,678.00	862,446,064.65
Найдваргүй авлагын зардал		
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал	1,469,763,953.69	2,540,976,663.69
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	328,309.85	10,770.73
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	0.00	7,009,987.95
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг/алдагдал	328,309.85	6,999,217.22
Татвар төлөхийн өмнөх цэвэр ашиг/алдагдал	1,470,092,263.54	2,533,977,446.47
Орлогын татварын зардал	131,760,597.52	263,843,322.20
Тайлант хугацааны цэвэр ашиг/алдагдал	1,338,331,666.02	2,270,134,124.27

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

